

АСЕАН, ТҮҮНИЙ ЭДИЙН ЗАСГИЙН ИНТЕГРАЦИ, ӨНӨӨГИЙН ЧИГ ХАНДЛАГА

*Ж. Уянга**

Зүүн Өмнөд Азийн улсуудын холбоо буюу АСЕАН нь анх таван гишүүн орнууд болох Малайз, Сингапур, Тайланд болон Филиппин улсуудын санаачлагаар Бангкок хотноо байгуулагдсан. Хожим нь 1984 оны 1-р сарын 8-нд Бруней улс, 1995 оны 7-р сарын 28-нд Вьетнам, 1997 оны 7-р сарын 2-нд Лаос, Мьянма улсууд, 1999 оны 4-р сарын 30-нд Кампучи улс тус тус нэгдэн оржээ. АСЕАН нь эдүгээ 500 сая гаруй хүн амыг хамарсан, 4.5 сая хавтгай дөрвөлжин километр газар нутагтай, 737 тэрбум ам.долларын дотоодын нийт бүтээгдэхүүнтэй, 720 тэрбум ам.долларын гадаад худалдааны эргэлт бүхий бүс нутгийн байгууллага болж өргөжсөн байна. Энэхүү холбооны зорилго бол бүс нутгийн ард түмний ая тухтай, тайван амьдралын үндэс суурийг бэхжүүлэх, тэгш эрхтэй, харилцан ашигтай хамтран ажиллаж бүс нутгийн эдийн засгийн өсөлт, нийгмийн дэвшил болон соёлын хөгжлийг хурдасгах, бүс нутгийн улс орнуудын харилцаанд шударга ёс, хуулийн хэм хэмжээг хүндэтгэн мөрдөж, НҮБ-ын дүрэмд заасан зарчмуудыг чанд баримтлаж бүс нутагт энх тайван, тогтвортой байдлыг дэмжих явдал юм.

АСЕАН байгуулагдах тэр үед гишүүн орнуудын хооронд худалдааны харилцаа дөнгөж эхлэлийн шатандаа байсан. Эхэн үед гишүүн орнуудын нийт худалдаанаас АСЕАН-ы дотоод дахь худалдаанд ноогдох хувь 12%-15% байсан. Худалдааны эргэлтийг сайжруулахын тулд хэд хэдэн арга хэмжээг хэрэгжүүлж эхэлсний нэг нь 1977 онд байгуулагдсан АСЕАН-ы орнуудын хоорондын худалдаанд тарифын хөнгөлөлт үзүүлэгч “Хөнгөлттэй худалдааны хэлэлцээр” байгуулсан явдал юм. Мөн Манилад болсон АСЕАН-ы 3 дахь дээд хэмжээний уулзалтаар АСЕАН-ы дотоод дахь худалдааг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн “Өргөжүүлсэн хөнгөлөлтэй худалдааны хэлэлцээрийн хөтөлбөрийг” баталжээ. Эдийн засгийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх гэрээ хэлэлцээрийг 1992 онд Сингапурт болсон АСЕАН-ы 4 дэх дээд хэмжээний уулзалтаар баталсан бөгөөд үүнд АСЕАН-ы чөлөөт худалдааны бүс буюу АФТА-н төлөвлөгөөг хэрэгжүүлж эхлэх асуудлууд багтсан ажээ.

АФТА-ын стратегийн зорилт бол үйлдвэрлэлийн нэгдсэн нэгжээр АСЕАН-ы бүс нутгийн өрсөлдөөний давуу талыг нэмэгдүүлэх явдал юм. Гишүүн орнуудын хооронд хийгдэх худалдаанд тарифын болон тарифын бус сааднуудыг багасгаснаар эдийн засгийн үр ашиг, бүтээмж, өрсөлдөх чадварыг улам их болгох боломж гарч ирсэн юм.

* Ж.Уянга - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Энэ бүс нутаг дулаан орны хөдөө аж ахуйн болон эрдэс баялгийн их нөөцтэй ажиллах хүч, үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын томоохон зах зээл билээ. Сүүлийн жилүүдэд АСЕАН-ы орнуудын удирдлага бүс нутгийн эдийн засгийн чадавхийг улам илүү нээж эрчимтэй хөгжихийн тулд өөр хоорондын болон олон улсын эдийн засгийн интеграцийг чухалчлах болсон юм.¹ АСЕАН-ы интеграцийн гол зорилго нь бүс нутгийн орнууд эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх явдал юм.

1997 онд АСЕАН-ы тэргүүнүүд “Хөгжлийн динамик дэх АСЕАН-ы түншлэл” хэмээн нэрлэгдсэн АСЕАН-ы хэтийн төлвийг баталсан билээ. Энэхүү төлөв нь 2020 он гэхэд бүс нутгийн эдийн засгийн интеграцийг дуусгаж, дүгнэлт өгөх зорилготой юм. Тус тунхаглал нь бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ хөрөнгө оруулалт, капиталын чөлөөт урсгал болон зах зээлийн шударга өрсөлдөөн бүхий тогтвортой, өндөр өрсөлдөөнтэй эдийн засгийн бүс байгуулах шийдвэр гаргасан юм.

Бүс нутгийн эдийн засгийн интеграцийн хүрээнд худалдаа ба хөрөнгө оруулалтыг чөлөөлөхөөс гадна улс доторхи хурдны зам ба төмөр замын сүлжээнүүд, боомтууд, далайн замууд, дотоодын усан замын тээвэр болон иргэний агаарын гол гол шугамуудаас бүрдэх Транс-АСЕАН-ы тээврийн сүлжээг хөгжүүлэх асуудал чухал байр эзэлж байгаа юм. Мөн АСЕАН-ы эрчим хүчний болон Транс-АСЕАН хий дамжуулах төслүүдээс бүрдэх Транс-АСЕАН-ы эрчим хүчний сүлжээнүүдийг бий болгох ажлууд хийгдэж байна.

АСЕАН-ы эдийн засгийн интеграцид хэд хэдэн зарчим үйлчилдэг. Тухайлбал, АСЕАН-ы гишүүн орон хамтын ажиллагааны санал санаачлага гаргаж түүнийг хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл боловсруулах эрхтэй.²

Хэдийгээр Зүүн Өмнөд Азийн улсуудын холбоонд багтдаг орнуудын хамтын ажиллагаа хөгжлийн тодорхой салбарууд эсвэл зөвхөн засгийн газруудын оролцоогоор хязгаарлагддаггүй ч АСЕАН-ы хамтын ажиллагааны хөтөлбөрүүд нь практик дээр 3 ерөнхий зорилтод чиглэгддэг. Эдгээр нь:

а. Төсвийн салбарын ажилтнууд, зарим үед олон нийтээс сонгогдсон төлөөлөгчдийг оролцуулсан солилцоогоор АСЕАН-ы өргөн хүрээтэй хамтын ажиллагааг дэмжих замаар АСЕАН-ы регионализмийг өргөжүүлэх;

б. Худалдааны болон эдийн засгийн практик үйл ажиллагааг зохицуулах замаар бүс нутгийн эдийн засгийн интеграцийг хөгжүүлэх;

в. Хувийн салбарт дэмжлэг тусламж үзүүлэх, дэлхийн эдийн засгийн эрчимтэй өөрчлөгдөж буй орчин нөхцөлд дасан зохицох, зохицуулалтын үйл явцад нэгдмэл байр сууринаас хандах замаар АСЕАН-ы өрсөлдөөний чадварыг нэмэгдүүлэх явдал юм.

Хөтөлбөрийн АСЕАН-ы бүсчлэлийг өргөжүүлэх зорилт нь гишүүн орон бүрийн хоёр талт гадаад харилцаан дахь уламжлалт солилцооны хөтөлбөрийг өргөжүүлэх явдал юм. Ийм төрлийн хөтөлбөрийн зорилт нь бүх 10 гишүүн орнуудын орллогчдыг хамарсан өргөн хүрээтэй солилцооны замаар АСЕАН-ы орнуудын ард иргэдийн дунд хамтын нийгэмлэгийн үзэл бодлыг тасралтгүй бий болгох, АСЕАН-ы яриа хэлцэлийн түнш орнуудтай хамтарч ажиллахад чиглэгдэнэ. Ийм өргөжүүлсэн солилцооны хөтөлбөр нь нийтийн үйлчилгээний ажилтнууд, мэргэжилтнүүд, бизнесийн лидерүүд, оюутнууд, залуу үеийнхнээс бүрдсэн холбогч бүлгүүдийг бий болгох замаар АСЕАН-ы регионализмыг бэхжүүлэхэд дэмжлэг болох ажээ. АСЕАН-ы хамтын ажиллагаа илүү боловсронгуй болж регионалист бүлгүүд болон АСЕАН-ы бүсчлэл өсөхийн хирээр хөтөлбөрийн үйл ажиллагаанууд бүс нутгийн интеграцийн чиг хандлагын дараачийн шатанд шилжих юм.

Бүс нутгийн эдийн засгийн интеграцид чиглэсэн хамтын ажиллагааны хөтөлбөрийн зорилт нь АСЕАН-ы орнуудыг бодит амьдрал дээр нэгтгэж, ялангуяа эдийн засаг, нийгмийн утгаар ямар нэг зааггүй бүс нутаг болгох явдал юм. Ийм төрлийн хөтөлбөрийн зорилт нь АСЕАН-ы бүс нутгийн хөгжлийг сайжруулах, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн эдийн засаг, нийгмийн салбаруудын практик үйл ажиллагаануудыг уялдуулан зохицуулахад оршино. Хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээн дэх нийтлэг үйл ажиллагаа болон төслүүд нь бодлого, хууль зүйн тогтолцоо болон институцийн механизмыг зохицуулах, бүс нутгийн бүрэн интеграцичлалд шаардлагатай өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэхэд гишүүн орнуудын институцийн чадавхийг бий болгоход чиглэгдсэн юм.³

Түүнчлэн АСЕАН-ы өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилт нь бүс нутгийн интеграцид өрсөлдөх чадвар сул бүлгүүдийг шинээр төрүүлэхгүй байлгахад чиглэсэн юм. Хөтөлбөрийн энэ зорилтын хүрээн дэх үйл ажиллагаанууд ба төслүүд нь АСЕАН-ы хамтын нийгэмлэг, хувийн салбарууд, жижиг дунд үйлдвэрүүд шинэ ба илүү өрсөлдөөнтэй зах зээлд дасан зохицохоор өөрөө зохицуулах үйл явцуудыг алхам алхмаар гүйцэтгэх тэдний чадварыг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ. Дэлхийн эдийн засагт гарч буй шинэ сорилтууд, боломжуудын талаарх мэдлэг туршлагыг түгээж, шинэ ур чадвар ба мэдлэгийн шаардлагуудыг нэвтрүүлснээр АСЕАН-ы өрсөлдөөний чадварын нийтлэг хөтөлбөр нь дэлхийн зах зээлийн өрсөлдөөнд бүс нутгийн хамтын нийгэмлэг, хувийн салбар жижиг, дунд үйлдвэрүүдийн бэлэн байдлыг нэмэгдүүлэхэд туслах болно.

Хөтөлбөрийн өнөөгийн чиг хандлага:

АСЕАН-ы хөгжлийн хамтын ажиллагаа нь одоо бүс нутгийн илүү өргөн хүрээтэй илүү хүчтэй интеграцид хүрэх чиглэлд явж байна. Бүс

нутгийн интеграци улам эрчимжиж байгаагийн үрээр АСЕАН-ы хамтын ажиллагаа өргөжин тэлсээр байгаа билээ. АФТА-г хэрэгжүүлж эхэлснээс хойшхи 3 жилийн хугацаанд АСЕАН-ы орнуудын дунд экспорт 43.26 тэрбум ам.доллар байсан бол 80 тэрбум ам.доллар болж нэмэгдэж, АСЕАН-ы нийт худалдаанаас бүс нутгийн дотоод дахь худалдаанд ноогдох хувь 20-25% хүртэл өсчээ. АСЕАН-ы ДНБ 600 тэрбум ам.доллараас давж, худалдаа эргэлт нь 800 тэрбум ам.долларт хүрчээ.⁴

АСЕАН-ы хөтөлбөрийн зорилго нь гишүүн орнууд хүчин чармайлтаа нэгтгэж АСЕАН-ы нийтлэг зорилтуудыг хамтран хэрэгжүүлэхэд чиглэгддэг учраас хөтөлбөртэй хамгийн их холбоотой салбаруудад хэрэгжиж байж сая түүний зорилго биелэх учиртай. Одоогийн байдлаар 13 бүлэг салбарт энэ хөтөлбөр хэрэгжиж эхлээд байна. Эдгээр нь:

1. Эдийн засгийн хамтын ажиллагаа:

- Худалдаа, хөрөнгө оруулалт, тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч, аялал жуулчлал, мөнгө санхүү

2. Үйл ажиллагааны хамтын ажиллагаа:

- Нийгмийн хөгжлийн салбар, байгаль орчин, шинжлэх ухаан ба технологи, хүнс, хөдөө аж ахуй ба ойн аж ахуй, соёл урлаг ба мэдээлэл, тусгай төслүүд зэрэг юм.

АСЕАН-ы Чөлөөт Худалдааны Бүс /АФТА/ байгуулах санаачлага эхэлснээс хойш АСЕАН нь эдийн засгийн бүрэн интеграцид хүрэх үйл явцын эхний үе шатандаа оржээ. Онолын хувьд бол эдийн засгийн бүрэн интеграцид хүрэхээс өмнө чөлөөт худалдаа нь гааль татварын холбоо, нэгдсэн зах зээл, дараа нь эдийн засгийн холбоо байгуулах асуудлыг дагуулдаг ажээ. АСЕАН-ы Чөлөөт Худалдааны Бүсийн анхны хэрэгжилт 2003 оноос эхэлсэн бөгөөд тарифын болон тарифын бус саад бэрхшээлүүдийг арилгах гэсэн байнгын хүчин чармайлтууд үр дүнд хүрч байгаа билээ. Өнөөгийн маргаантай асуудлууд бол улсын хилүүд дээр шаардлагатай байгаа зохицуулалтын механизмуудыг бий болгох явдал юм. Иймд эдгээр асуудлуудыг нэг зэрэг шийдвэрлэхэд АСЕАН-ы хөгжлийн хамтын ажиллагааг улам хөгжүүлэх шаардлага зүй ёсоор гарч ирж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. С.Дашцэвэл “Зүүн Өмнөд Азийн хөгжлийн хандлага, интеграци, Монгол Улсын бодлого чиглэл”, УБ, 2005
2. Мөн тэнд
3. Интернет
4. Н.М.Хряшева “Внешне-экономические связи и развитие стран Юго-Восточной Азии”